

**2023 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 26-НЫ ӨДРИЙН  
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД ДҮҮРГИЙН УДИРДАХ  
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

Үүргийн биелэлтийг Arial-12 фонтоор бичиж, 2023 оны 09 дүгээр сарын 29-ний “Баасан” гарагийн дотор e-doc системээр албан бичгээр ирүүлж, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (ERP Б.Одбаяр)-т файлаар ирүүлнэ үү. Хугацаа хэтэрсэн, албан бичгээр ирүүлээгүй тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцохыг анхаарна уу.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
<b>НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР</b>		
<b>БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД</b>		
1	Бодлогын баримт бичиг болон хууль, тогтоол, шийдвэр, шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг сайтар хангаж, удаашралтай байгаа ажлуудаа эрчимжүүлж, хяналт тавьж ажиллах.	Нийт байгууллагууд
2	Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 37 дүгээр тэмдэглэлийн дагуу орон нутгийн өмчит хуулийн этгээдийг нэгтгэх, нийлүүлэх, татан буулгах замаар өөрчлөн байгуулах, нэгдсэн зохион байгуулалтад оруулах санал боловсруулж танилцуулах.	ТЗУХ, СТСХ, ААТҮГ-ууд
<b>ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД</b>		
3	Дүүргийн хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл ажлыг сайтар хангах, мэргэжлийн чиг үүргийн байгууллагууд өвлийн их ачааллын үед иргэдийг ус, дулаан, цахилгаан эрчим хүчээр найдвартай хангахад онцгой анхаарч ажиллах.	ЗДО Б.Болормаа, ТХҮХ, инженерийн дэд бүтцийн байгууллагууд
<b>ЦАГ ҮЕИЙН АСУУДЛЫН ХҮРЭЭНД</b>		
4	Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээ /RFID TAG/-г суурилуулахтай холбоотой ажлыг эрчимжүүлэх.	ЗДТГ-ын дарга Л.Санжийжамц, ТЗУХ
5	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан өргөдөл, гомдол, албан бичгийг хууль зүйн үндэслэлтэйгээр эцэслэн шийдвэрлэж, хуулийн хугацаанд иргэнд хариу өгч ажиллах.	ТЗУХ, Нийт байгууллагууд
6	Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн дагуу төсвийн зардлын хэмнэлтийг хэрэгжүүлэх, төсвийн сахилга батыг сайжруулж, дотоод хяналт шалгалтаа сайжруулж, үр дүнг шаардаж ажиллах.	Нийт байгууллагууд
7	Мэргэжлийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж байгаа мэргэжилтэн болон холбогдох ажлын хэсэг төрийн хяналт шалгалтын ажлаа эрчимжүүлж, хэрэгжилтэд анхаарч ажиллах	Холбогдох ажлын хэсэг
8	Ерөнхий боловсролын сургуулийн орчинд сурагчид, хүүхэд багачуудыг зам, тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад туслах ажилтан, олон нийтийн цагдаагийн ажилтан, эргүүлийн цагдааг томилон, явган хүний гарц, гарамтай хэсгүүд дээр ажиллуулж, эрчимжүүлж ажиллах.	Цагдаагийн хэлтэс, Боловсролын хэлтэс, ЕБС, СӨБ-ын байгууллагууд
9	Орон сууцны болон гэр хорооллын хог тээвэрлэлтийг нэмэгдүүлж, ажлаа эрчимжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.	ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
10	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудаа эрчимжүүлэх. Үүнд /Тохижилт, ногоон байгууламж, барилга, байгууламж, авто замын засвар шинэчлэл/	ЗДО Б.Болормаа СТСХ, ХААА, ТХҮХ
11	Нийгмийн салбарын ажлуудыг эрчимжүүлж, иргэд олон нийтийг соён гэгээрүүлэхэд анхаарч, хийсэн ажлын үр дүнг танилцуулах.	НХХ, нийгмийн салбарын байгууллагууд
12	Авто тээврийн шалган бүртгэх товчоодын хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэх.	Цагдаагийн хэлтэс, ОБХ

ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
13	Ахмадын баярыг тохиолдуулан зохион байгуулагдах “Ахмадаа сонсьё” аяны бэлтгэлийг сайтар хангаж, нийслэлд зохион байгуулагдах үйл ажиллагаанд оролцох боломжоор хангах, харьяалагдах ахмадуудаа хүлээн авах	ЗДО Б.Болормаа НХХ Нийт байгууллагууд
14	Улаанбаатар хотын 384 жилийн ойн өдрөөр зохион байгуулагдах арга хэмжээний төлөвлөгөөг дүүрэг, орон нутгийн онцлогт тохируулан шинэлэг хэлбэрээр төлөвлөх.	НХХ
15	Дүүргийн 1, 2 дугаар хорооны СӨХ нь нөөцөөс гаргуулсан төсвийнхөө хүрээнд холбогдох засварын ажлуудаа эрчимжүүлж энэ 7 хоногтоо багтаан дуусгах.	ТХҮХ, СӨХ
16	Хувийн хэвшлүүдтэй уулзах уулзалтын бэлтгэлийг сайтар хангаж, холбогдох байгууллагын удирдлагууд идэвхтэй оролцох	ЗДТГ-ын дарга Л.Санжийжамц Татварын хэлтэс, ХХҮХ, ОБХ, ЦХ НДХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ, ГЗБА, ХААТ
17	Улаанбаатар-Чойр чиглэлийн улсын чанартай А0101 авто замын дагуу түүвэр цэвэрлэгээ зохион байгуулж ажиллах	Багахангай тохижилт ОНӨААТҮГ
18	ЗДТГ-т бүртгэлтэй худгуудын арчлалт хамгаалалттай холбоотой гэрээг шинэчлэх боломж нөхцлийг судалж, эзэмшигчидтэй уулзалт зохион байгуулан асуудлыг шийдвэрлэх.	ЗДТГ-ын дарга Л.Санжийжамц ТЗУХ, ТХҮХ, Хороод
19	2024 онд дүүрэг байгуулагдсаны 35 жилийн ой тохиох тул хууль, эрх зүйн хувьд тэгш ойн статустай тэмдэглэн өнгөрүүлэх эсэхийг судалж тогтоох.	ЗДО Б.Болормаа, ТЗУХ
20	Мах боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг сэргээх, өмчлөхтэй холбогдуулан нийслэлийн Өмчийн харилцааны газартай холбогдож тодруулах	ЗДО Б.Болормаа
21	ХЦС-д гал тогооны тоног төхөөрөмж олгохыг хүссэн бичгийг нийслэлийн Засаг даргын орлогч З.Төмөртөмөөд дахин хүргүүлэх.	НХХ, ХЦС
22	“Сүүдрэвчтэй худалдаа”-г зохион байгуулахаар дүүргийн 1, 2 дугаар хороонд байршуулсан сүүдрэвчийг ашиглахтай холбогдуулан холбогдох хяналт тавьж ажиллах	ТХҮХ, Цагдаагийн хэлтэс

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР